



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/32

Ханх сум

**Хагас жилийн мал тооллогын комисс  
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.2024 оны хагас жилийн мал тооллого, түүвэр судалгааг өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах ажлыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттүвшин (Засаг даргын орлогч)  
Ш.Отгонжаргал (Тураг 1-р багийн Засаг дарга)  
Б.Анхбаяр Хороо 2-р багийн Засаг дарга)  
Э.Мөнхжаргал (Турт 3-р багийн засаг дарга)  
Б.Бямбабаяр (Баясгалант 4-р багийн Засаг дарга)  
Нарийн бичиг: Ж.Батцэцэг (Санхүү албаны дарга)

2.Мал тооллогын ажлын хэсэг нь хариуцсан нутаг дэвсгэртээ дээд байгууллагаас өгсөн удирдамжийн дагуу тооллогын ажлыг зохион байгуулж, үр дүнг шивж нэгтгүүлэхийг тооллогын комиссын дарга, нарийн бичиг, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тооллогын ажилд зарцуулах 1,405,734 (нэг сая дөрвөн зуун таван мянга долоон зуун гучин дөрөв)-н төгрөгийг статистикийн хэлтсээс ирүүлсэн хагас жилийн мал тооллогын зардлын задаргааны дагуу тооцож гаргахыг нягтлан бодогч (Б.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР

